

**“УЛААНБААТАР ДУЛААНЫ СҮЛЖЭЭ”  
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ  
КОМПАНИ**

**Огноо: 2019-03-07**

**“ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ МАТЕРИАЛ” НИЙЛҮҮЛЭХ  
ҮНИЙН САНАЛ АВАХ БАРИМТ БИЧИГ**

Төслийн нэр:  
Төслийн дугаар:

Цэвэрлэгээний материал нийлүүлэх.  
УЗ-2019/01

**Улаанбаатар хот**

## Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

“Улаанбаатар Дулааны Сүлжээ” ТӨХК нь эрх бүхий тендерт оролцогчдоос “Цэвэрлэгээний материал”-ыг нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **2019 оны 03-р сарын 15-ны** өдрийн **11 цаг 00 минутаас** өмнө [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) цахимаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2019 оны 03-р сарын 15-ны** өдрийн **11 цаг 20 минут<sup>1</sup>**-т нээнэ.

Дотоодын давуу эрх тооцох эсэх.<sup>2</sup> Тооцохгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

*Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 3-р хороо, Ф.Энгельсийн гудамж,  
“Улаанбаатар Дулааны сүлжээ” ТӨХК-ийн төв байр, 2 давхар 204 тоот өрөө  
Утас: 75753047-242, 99074011, Факс: +976-11-342397.*

---

<sup>1</sup> Тендерийг хүлээж авах эцсийн хугацааг дууссанаас хойш 1 цагийн дотор байна.

<sup>2</sup> Захиалагч тендер шалгаруулалтад давуу эрхийн зөрүү хэрэглэхгүй бол, энэ өгүүлбэрийг хасч оронд нь “Монгол Улсын гарал үүсэлтэй бараанд давуу эрхийн зөрүү тооцохгүй” гэж бичнэ.

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

1. **Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**
  - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
2. **Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
  - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
  - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
3. **Тендерийн иж бүрдэл**
  - 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
    - (а) Үнийн санал;
    - (б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;
    - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
    - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
    - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
4. **Тогтмол үнэ**
  - 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
5. **Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**
  - 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
  - 5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
6. **Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
  - 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **45** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
7. **Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
  - 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
  - 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
  - 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.

**8. Гэрээ  
байгуулах эрх  
олгох тухай  
мэдэгдэл**

8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах гэрчилгээ, зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>• Компанийн улсын бүртгэлийн гэрчилгээний эхийн хуулбар</li> <li>• Татварын өр төлбөргүй тухай тодорхойлолт</li> </ul>
ТӨӨЗ 2.1	Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:  Байгууллагын хаяг: цахим тендер <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a>  Огноо: <b>2019 оны 03 дугаар сарын 15-ны өдөр</b>  Цаг: <b>11 цаг 00 минут</b>
ТӨӨЗ 2.2	Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:  Байгууллагын хаяг: <b>Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 3-р хороо, Ф.Энгельсийн гудамж, “Улаанбаатар Дулааны сүлжээ” ТӨХК-ийн байр.</b>  Давхар болон өрөөний дугаар: <b>2 давхар 204 тоот</b>  Огноо: <b>2019 оны 03 дугаар сарын 15-ны өдөр</b>  Цаг: <b>11 цаг 20 минут</b>
ТӨӨЗ 3.1 а	Батлагдсан маягтын дагуу үнийн санал ирүүлэх
ТӨӨЗ 3.1 б	Бараа нийлүүлэх хуваарь ирүүлэх
ТӨӨЗ 3.1 д	Ажлын туршлагын мэдээлэл, ижил төстэй бараа нийлүүлсэн тухай мэдээлэл -сүүлийн 2 жилд дор хаяж 1 удаа
ТӨӨЗ 3.1 д	Тендерийн баримт бичгийн бүрдэл монгол хэл дээр байна
ТӨӨЗ 5.1	Техникийн тодорхойлолтыг өгөгдсөн техникийн тодорхойлолтой харьцуулж баталгаажуулж ирүүлэх. гадаад хэл дээр бол орчуулах.

## ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

### 1. Барааны тодорхойлолт: Цэвэрлэгээний материал

**Баглаа, боодол:** Үйлдвэрийн стандарт баглаа боодол.

### 2. Бараа хүргэх газар: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 3 дугаар хороо, Ф.Энгельсийн гудамж, Улаанбаатар дулааны сүлжээ” ТӨХК-ийн өөрийн байр

Д/д	Материалын нэр	Хэмжээ	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Тавигдах шаардлага
1	00 угаах сойз		ш	24	00 өрөөний хананд тогтоох боломжтой, стандарт хэмжээтэй, цагаан өнгөтэй, сайн чанарын евро стандартыг хангасан
2	00 цаас тогтоогч	500м	ш	6	00 өрөөний хананд тогтоох боломжтой, стандарт хэмжээтэй, никель хуванцар материалтай, сайн чанарын евро стандартыг хангасан ,/ 500м ийн 00 цаас тогтоох/
3	00 цэвэрлэх бодис /комет ба бусад/	750гр	ш	100	хуурай нунтаг , хуванцар савтай, евро стандартыг хангасан /комет эсхүл түүнтэй дүйцэх/
4	00 цэвэрлэх бодис /утенок ба бусад/	750гр	ш	24	шингэн , евро стандартыг хангасан /утенок эсхүл түүнтэй дүйцэх/
5	Агааржуулагч	300мл	ш	216	шингэн хий хэлбэрийн, хурц үнэр дарах , цацдаг, евро стандартыг хангасан /Glade Perfection агааржуулагч эсхүл түүнтэй дүйцэх /
6	Илгэн алчуур /том/	50x50см	ш	146	евро стандартыг хангасан, ус шингээх чадвартай, зөөлөн материалтай /гайхмаараа эсхүл түүнтэй дүйцэх/
7	Арчих материал /хөл арчих/	120x60см	ш	50	120x60 ийн хэмжээтэй, цайвар, зузаан хөвөн даавуун материалтай
8	Арчих материал /цагаан даавуу/	60см өргөнтэй	м	606	цагаан, ус шингээх чадвар өндөртэй, 60 см ээс багагүй өргөнтэй. /гүзээ даавуу/
9	Аяга таваг угаагч бодис	400мл	ш	120	Тос арилгах, сайн чанарын евро стандартыг хангасан. /Ферри эсхүл дүйцэх/
10	Ариутгалын бодис	1л,	ш	132	ОХУ, Солонгос улсад үйлдвэрлэсэн ариутгалын бодис /Белизна эсхүл дүйцэх/
11	Бүх төрлийн гадаргуу угаагч	750мл	ш	120	Бүх төрлийн толбо арилгагч SIR - 12sba007 эсхүл түүнтэй дүйцэх
12	Гар ариутгалын шингэн	1л	ш	48	санитос эсхүл дүйцэх
13	Гарын шингэн саван 4л	4л	ш	48	ОХУ, Солонгос, Турк улсад үйлдвэрлэсэн. Евро стандартыг хангасан

14	Мебель өнгөлөгч	250мл	ш	48	ОХУ, Солонгос, Турк улсад үйлдвэрлэсэн.Евро стандартыг хангасан. хий хэлбэртэй цацдаг. /pronto эсхүл түүнтэй дүйцэх/
15	ОО цаас	том	ш	720	3 давхар, усанд уусах чадвартай, 500м урттай, стандарт өргөнтэй
16		жижиг	ш	60	3 давхар, усанд уусах чадвартай, 50гр, стандарт өргөнтэй
17	Паркетан шал өнгөлөгч	1л,	ш	96	ОХУ, Солонгос, Турк улсад үйлдвэрлэсэн.Евро стандартыг хангасан
18	Плита угаагч	1л,	ш	48	ОХУ, Солонгос, Турк улсад үйлдвэрлэсэн.Евро стандартыг хангасан
19	Резин бээлий		хос	156	Солонгос улсад үйлдвэрлэсэн
20	Эдийн саван	200гр	ш	666	Монгол улсад үйлдвэрлэсэн /ТОП, ОК эсхүл дүйцэх/
21	Суултуурын цаас		боодол	24	ОХУ, Солонгос, Турк улсад үйлдвэрлэсэн.Евро стандартыг хангасан
22	Угаалгийн нунтаг	6кг	ш	60	ОХУ, Солонгос, Малайз улсад үйлдвэрлэсэн /ОМО эсхүл дүйцэх/
23	Угаалгийн нунтаг	1кг	ш	26	ОХУ, Солонгос, Малайз улсад үйлдвэрлэсэн /ОМО эсхүл дүйцэх/
24	Үнэр дарагч		ш	30	00 цэвэрлэгч, тос зэв арилгах шахмал, ОХО 206150 эсхүл дүйцэх
25	Хивс цэвэрлэгч	5l	ш	24	ОХУ, Солонгос, Турк улсад үйлдвэрлэсэн.Евро стандартыг хангасан
26	Хлорамин		ш	552	таблеткан хэлбэртэй ариутгалын бодис
27	Хогийн уут /том/	80x100см	боодол	150	МУ-д үйлдвэрлэсэн
28	Хогийн уут /жижиг/	30x50см	боодол	90	МУ-д үйлдвэрлэсэн
29	Шетка	3	ш	22	жижиг
30	Шил арчигч	1л	ш	168	Шил толь цэвэрлэгч SIR - 12sba008 эсхүл дүйцэх
31	Гарын шингэн савангийн сав		ш	10	00 өрөөний хананд тогтоох боломжтой, стандарт хэмжээтэй, никель хуванцар материалтай, сайн чанарын евро стандартыг хангасан /00 цаас тогтоогчтой нэг ком байх /

**Бараа нийлүүлэлтийн хуваарь:**

**БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ**

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
Цэвэрлэгээн ий материал			Иж бүрдэл	УБДС ТӨХК өөрийн байр	Гэрээ байгуулагдсан даруйд	Гэрээ байгуулагдсан санаас хойш 14 хоногийн дотор	



## 1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

**УБДС-ТӨХК**-ын Гүйцэтгэх захирал **Ч.Саранжав** танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс хойш 45 хоног хүчинтэй байна.
4. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## 2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БҮЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/фак с	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

## Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- |  |   |
|--|---|
| 1. Шалгах болон турших                             | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.   |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх                                | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.  |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх     | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томьёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.  |
| 5. Баталгаат засварын хугацаа                      | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа <b>[тоо]</b> жил байна.   |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах                        | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.   |
| 7. Төлбөр  | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш <b>[ГТН-д заасан тоо]</b> хоногийн дотор шуурхай хийнэ.  |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь                         | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.   |
| 9. Алданги оногдуулах                              | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.  |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах         | 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.   |
| 11. Маргааныг шийдвэрлэх                           | 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.  |

## Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- 1. Шалгах болон турших (ГЕН – 1)**
- 1.1. [Барааны шалгалт туршилтыг захиалагчийн комисс өөрийн байранд хийж актаар хүлээлцэнэ.]
- 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)**
- 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
  - 2) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
  - 3) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
  - 4) барааны гарал үүслийн гэрчилгээ.
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
- 3. Баталгаат засвар (ГЕН-5)**
- 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.  
[Баталгаат засварын хугацаа 3 жил]
- 4. Төлбөр (ГЕН – 7)**
- 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
- Гэрээний үнийн дүнгийн 100 хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.
- 5. Алданги оногдуулах (ГЕН - 9)<sup>3</sup>**
- 9.1. Алданги оногдуулах хувь: 0,5%  
Алдангийн нийт дүн: 10%

<sup>3</sup> Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

**БАТЛАВ.**

**ЗАХИАЛАГЧ**

**НИЙЛҮҮЛЭГЧ**

\_\_\_\_\_  
(Тамга, тэмдэг)  
\_\_\_\_\_  
(Гарын үсэг)  
\_\_\_\_\_  
(Албан тушаал)

\_\_\_\_\_  
(Тамга, тэмдэг)  
\_\_\_\_\_  
(Гарын үсэг)  
\_\_\_\_\_  
(Албан тушаал)

**[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.**

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_ сарын \_\_\_\_ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг \_\_\_\_\_ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь \_\_\_\_\_ нэр төрлийн барааг \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_-наас \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_\_\_ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;  
Бусад шаардлагатай баримт бичиг<sup>5</sup>;  
Үнийн санал;

<sup>4</sup> Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

<sup>5</sup> Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээний тусгай нөхцөл;  
Гэрээний ерөнхий нөхцөл;  
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;  
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг]\_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг]\_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]